



СОЁМБО

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МЭЭДЭЭ

№178
/388/

2022.10.05



МЭНДЧИЛГЭЭ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Г.САЙХАНБАЯР

Монгол Улсад шинэ цагийн боловсрол, соён гэгээрүүлэх их үйлсийг эхлүүлсэн нэгэн зууны түүхэн замналтай Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны улаан тугийн одон, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн эрхэм хүндэт багш, сурган хүмүүжүүлэгч, эрдэмтэн судлаачид Та бүхэндээ “Монголын багш нарын өдөр”-ийн баярын мэндчилгээг өргөн дэвшүүлье.

Монголчууд бид эрдэм ном эрхэм баян хэмээж, багшаа хүндлэн дээдэлж, багш, шавийн барилдлагыг дээдэлдэг нандин уламжлалтай ард түмэн билээ.

Эх орноо батлан хамгаалах ирээдүй хойч үеийг мэдлэг, боловсролтой төдийгүй эрүүл чийрэг бие бялдартай, зөв ёс суртахуун, хүмүүжил, төлөвшилтэй, эх оронч, үндэсний бахархалтай болгон хөгжүүлэх үйлсэд эрдэм мэдлэг, авьяас чадвар, хүч чадлаа дайчлан ажиллаж байгаа Та бүхнээрээ бид ямагт бахархаж байдаг юм.

Монгол Улсын төр засгаас их, дээд сургууль, мэргэжлийн боловсролын байгууллагуудын үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцоо, инновацын менежментийг нутагшуулах, эрдэм шинжилгээ, боловсрол, сургалтын агуулга, арга зүйг олон улсын жишигт хүргэх, судалгааны болон судалгаанд суурилсан их сургууль болгон хөгжүүлэх бодлогыг баримталж байна.

Улс орны тогтвортой хөгжил, аюулгүй байдлыг хангахад шаардлагатай батлан хамгаалах чадавхыг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, боловсрол, эрдэм шинжилгээ, хүний хөгжлийн орчин үеийн цогц орчинг үе шаттайгаар хөгжүүлж, олон улсын нийтлэг жишигт ойртсон судалгаанд суурилсан их сургууль болох эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд багш, сурган хүмүүжүүлэгч, эрдэмтэн судлаачдын гүйцэтгэх үүрэг чухал юм.

Боловсролын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд тус сургуулийн сургалтын үйл ажиллагааг явуулахад нэн шаардлагатай “Үндэсний аюулгүй байдлыг хангах мэргэжлийн чиглэлээр дээд боловсролын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг зөвхөн цэрэг, цагдаагийн сургалттай төрийн өмчийн их, дээд сургуульд олгох”, “Цэрэг, цагдаагийн их сургууль нь ерөнхий боловсролын дунд сургуультай байж болох” зэрэг олон чухал эрх зүйн зохицуулалтыг тусгуулахаар ажиллаж байна.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр тус сургуулийн бүтцэд “Цэргийн хөгжмийн коллеж”, “Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв”-ийн статусыг баталгаажуулж, Цэргийн нэгдсэн дээд сургуулийн сургалтыг 4 жилийн тогтолцоонд шилжүүлэх тухай шийдвэрийг гаргалаа.

ҮБХИС-ийн хөгжлийг дэмжих ажлын хүрээнд “Кибер аюулгүй байдлын сургалтын төв”-ийг шинээр байгуулж, “Төв номын сан”-гийн шинэ барилгыг ашиглалтад хүлээн аваад байгаа бөгөөд цаашид “Нэгдсэн лаборатори”, “Алба хаагчдын хүүхдийн цэцэрлэг”, “Оюутны дотуур байр”, “Жагсаалын талбайн шинэчлэлт” зэрэг томоохон төсөл, хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Цаашид боловсролын эрх зүйн орчны шинэчлэлийг хэрэгжүүлэх, их сургуулийн сургалт, эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх, туршилт, судалгаа явуулах нөхцөлийг сайжруулах, шинэ шатанд гаргах, чанарыг ахиулах, багш, эрдэмтэн, судлаачдын нийгмийн баталгааг дээшлүүлэхэд анхаарал хандуулах болно.

Эрхэм хүндэт багш, сурган хүмүүжүүлэгчид Та бүхэндээ соён гэгээрүүлэхүйн их үйлсэд тань амжилт хүсэж, сайн сайхан бүхнийг ерөөе.

Эрхэм баян-Эрдэм ном дэлгэрэх болтугай!

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ УДИРДАХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЗААХ АРГА ЗҮЙН ЦУГЛАРАЛТ БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ



Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний заах арга зүйн цугларалт “Удирдах бүрэлдэхүүний манлайлал-цэргийн сургалт бэлтгэлд нөлөөлөх нь” сэдвээр гурав хоногийн хугацаанд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө.

Энэ удаагийн цугларалтаар Зэвсэгт хүчний бэлэн байдлыг хангахад удирдах бүрэлдэхүүний манлайлах ур чадвар цэргийн сургалт бэлтгэлд нөлөөлөх арга замыг тодорхойлж, тэдний манлайллыг нэмэгдүүлэх, 2022-2023 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн зорилго, зорилт, зохион байгуулж явуулах онцлог, туршлага сургамж, дүгнэлт, цаашид хийж хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэний дээр удирдах бүрэлдэхүүний үзэл бодол, санал хүсэлтийг сонсож тулгамдаж буй асуудлуудыг хамтын хүчээр шийдвэрлэсэн юм.

Мөн цугларалтын үйл ажиллагааг хааж ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг удирдах бүрэлдэхүүнд үүрэг чиглэл өгсний дараагаар СБГ-ын дарга бригадын генерал Г.Болор цугларалтын үр дүнг танилцуулж, нийт бие бүрэлдэхүүнд сертификат гардууллаа.

СОЁМБО
РЕДАКЦ

Батлан хамгаалах салбарын
хөгжөл мэдээллийн байгууллага

ИДЭВХ ЗҮТГЭЛЭЭРЭЭ МАНЛАЙЛАН ОРОЛЦСОН ТА БҮХЭНД БАЯРЛАЛАА



ЗХЖШ-ын Сургалт, бэлтгэлийн газрын дарга бригадын генерал Г.БОЛОР:
-Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний

цугларалт амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Бид манлайлал гэж юу вэ гэдэг талаар бие бүрэлдэхүүнд онолын ойлголтыг өгсний дараагаар бүлгийн хэлэлцүүлэг өрнүүлэх хэлбэрээр тус цугларалтыг зохион байгуулсан. Энэ удаагийн цугларалтаар гадаадад мэргэжил дээшлүүлж, боловсрол эзэмшсэн алба хаагчид нийт бие бүрэлдэхүүнд туршлага, мэдлэг, боловсролоо хуваалцсан нь бас нэг шинэлэг бөгөөд давуу тал байж чадлаа.

Мөн Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзоригт "Төрийн албаны шинэтгэлийн зарим асуудал" сэдвээр бие бүрэлдэхүүнд илтгэлээ танилцуулсан нь ач холбогдол өндөр, үр дүнтэй сайхан хэлэлцүүлэг боллоо. Ташрамд хэлэхэд гурав хоногийн хугацаанд идэвх зүтгэлээ гаргаж цугларалтад оролцсон удирдах бүрэлдэхүүн, ЗХЖШ-ын удирдлагын болон Сургалт бэлтгэлийн газрын хамт олондоо чин сэтгэлийн талархал илэрхийлэе.

МАШ ОЛОН ЗҮЙЛИЙГ СУРЧ АВСАНДАА БАЯРТАЙ БАЙНА

ЗХЖШ-ын ахлагч, тэргүүн ахлагч Н.БААСАН:

-Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний заах арга зүйн цугларалтыг энэ удаа "Удирдагч хүний манлайлал цэргийн сургалт, бэлтгэлд хэрхэн нөлөөлөх вэ" гэсэн сэдвийн хүрээнд зохион байгуулж байгаа нь өмнөх жилүүдийг бодвол илүү шинэлэг, өвөрмөц санагдаж байна. Тус цугларалтаар манлайлагч хүн ямар байдаг, манлайллыг хэрхэн төлөвшүүлэх талаарх сургалтуудыг олон сонирхолтой хэлбэрээр зохион байгууллаа. Мөн сургалтынхаа орчин нөхцөлийг өөрчилсөн, хүн бүр суралцагч бус оролцогч хэлбэрээр цугларалтад хамрагдсаны зэрэгцээ хоорондоо санал бодлоо хуваалцсан онцлогтой сургалт болж өндөрлөлөө. Маш олон зүйлийг сурч чадсандаа баяртай байна. Мөн түүнчлэн ирэх оны 1 дүгээр сард Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын ахлагч нарын цугларалтыг зохион байгуулахдаа удирдах бүрэлдэхүүний энэ удаагийн цугларалтын онцлогийг жишиг болгон ажиллахаар төлөвлөж байна.



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
"Соёмбо" сонин
"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс: 10018
Цахим шуудан:
Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)